

1. “HR Club”-тэй хамтран ажиллах талаар ярилцлаа

Төслийн ахлах зөвлөх болон холбогдогч ажилчид “Манлайлагч хүний нөөцийн холбоо (HR Club)”-ны тэргүүн Ш. Баярмагнай, удирдах зөвлөлийн гишүүн О.Дүүриймаа нартай уулзлаа. Манлайлагч хүний нөөцийн холбоо нь гишүүн байгууллагуудынхаа хүний нөөцийг хөгжүүлэх, хүний нөөцийн сүлжээг бий болгох замаар корпорацыг хөгжүүлэх зорилгоор 2012 онд байгуулагджээ. HR Club нь ХНХЯ, ХБХХЕГ-тай хамтран залуучууд болон ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажилладаг. Хувийн хэвшлийн 15000 байгууллага гишүүнээр элссэн байдаг.



“HR Club”-ын удирдах албаны хүмүүсийн хамт

DPUB 2 төсөл ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ААНБ-уудад нөлөөлөх тал дээр түлхүү анхааран ажиллаж байна. Тиймээс бид HR Club-тай хамтран хувийн хэвшлийн ААНБ-уудад нөлөөлөх, ажлын байрны дадлагажуулагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх, ХБИ-ийн хөдөлмөрт бэлтгэх сургалт зэрэг олон талаар хамтран ажиллах боломж байгааг ярилцлаа. DPUB 2 төсөл цаашид HR Club-тэй хамтран ААНБ-уудын хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаа явуулахыг зорьж ажиллана.

2. “Ажлын байрны дадлагажуулагчийн талаарх анхан шатны семинар” амжилттай зохион байгуулагдлаа



Семинар зохион байгуулагдсан танхим

Ажлын байрны дадлагажуулагчийн анхан шатны семинар зохион байгуулагдлаа.

DPUB2 төсөл 3-сарын 28, 29-ний өдрүүдэд “Ажлын байрны дадлагажуулагчийн талаарх анхан шатны семинар”-ыг зохион байгуулж байна. Семинарыг нээж ХНХЯ-ын Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир үг хэлсний дараа төслийн ахлах зөвлөх Чибса Хисао төслийн үйл ажиллагааны талаар товч танилцууллаа. Ковид-19 цар тахлын улмаас багш нар Япон улсаас

цахимаар холбогдож, зайнаас семинарыг удирдан явуулж байна.

Семинарын эхний өдөр буюу 3-р сарын 28-нд багш нар Ажлын байрны дадлагажуулагчийн талаар анхан шатны ойлголт өгөх зорилгоор үндсэн 4 сэдвийн хүрээнд лекц тавилаа. Оролцогч нар бүгд хичээнгүйлэн идэвхтэй оролцож буйд төслийн багийнхан үнэхээр их баяртай байна. Мишээл группын захиргаа, хүний нөөцийн албаны дарга Б.Төвшинтөгс “Хичээлийн сэдэв үнэхээр сонирхолтой байлаа.

СЭДЭВ

“HR Club”-тэй хамтран ажиллах талаар ярилцлаа

1

“Ажлын байрны дадлагажуулагчийн талаарх анхан шатны семинар” амжилттай зохион байгуулагдлаа

2

DPUB2
Монгол Улс
дахь ХБИ-ийн
хөдөлмөр
эрхлэлтийг
дэмжих
тогтолцоог
бэхжүүлэх
төсөл

Хүн бүр мэддэг ч бидний тэр бүр хэрэгжүүлээд байдаггүй нарийн зүйлсийг зааж өгч буйд туйлын баяртай байна. Мөн ажлын байрны дадлагажуулагч болох хүн маш сайн туршлага хуримтлуулах хэрэгтэй юм байна” хэмээн ярьж байлаа.

Семинарын эхний өдөр Япон мэргэжилтэн багш нар “Ажлын байрны дадлагажуулагчийн чиг үүрэг, үндсэн ойлголт”-ын талаар танилцуулсан билээ. Хоёр дахь өдөр буюу 3-р сарын 29-ний өдөр ажлын байрны дадлагажуулагч хэрхэн ажилладаг талаар дүрд орж тоглох практик дасгал ажил хийлээ. Үдээс өмнө оролцогчид 4 багт хуваагдаж, хүн бүр ажлын байрны дадлагажуулагчийн дүрд тоглон “ХБИ-ийг ажиллуулах боломжтой эсэх талаар ААНБ-тай уулзалт хийх” гэсэн сэдвээр дасгал ажил хийлээ.

Үдээс хойш “Ойлгомжтой заах арга барил буюу системтэй зааварчилгаа” гэсэн сэдвээр дүрд орж тоглосон юм. Энэхүү дасгал ажлын хүрээнд ажлын дараалал, хэрэглэгдэхүүний нэрийг ойлгомжтой нэрлэн зааварчлаа, алдааг нь засаж заах гэх мэт дэмжлэг үзүүлэх үйл явцын үндсэн зарчмыг баримтлан ойлгомжтой байдлаар заах арга барилаас суралцсан юм. Дасгал ажлын төгсгөлд Япон мэргэжилтэн багш нар болон оролцогчид алдаа оноотой зүйлээ дүгнэн ярилцлаа.

Үргэлжлэл 1-р нүүрт



Багийн ажил явагдаж буй байдал



Дүрд орж тоглох дасгал ажлын үеэр

Семинарын төгсгөлд төслийн ахлах зөвлөх Чибэ Хисао Монгол Улсад ажлын байрны дадлагажуулагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг нэвтрүүлэхэд төр, ТББ, ААНБ-уудын үүрэг, хариуцлага нэн чухал болохыг дахин онцоллоо. Оролцогчдыг төлөөлөн “Сонор” МСҮТ-ийн захирал Баянзул сэтгэгдлээ хэлэв. Төслийн баг, Япон мэргэжилтэн багш нарт гүн талархал илэрхийлэхийн зэрэгцээ ХНХЯ-ны холбогдох ажилтнуудад хандан ажлын байрны дадлагажуулагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг төрийн бодлогын хүрээнд дэмжиж ажиллахыг хүсэж буйгаа илэрхийллээ.

Энэ удаагийн семинарт хоёр өдрийн турш идэвхтэй оролцсон та бүхэнд DPUB2 төслийн хамт олноос гүн талархал илэрхийлж байна.



Хаалтын үйл ажиллагааны дараа дурсгалын зураг татуулав



dpub.jica@gmail.com



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5 Улаанбаатар-15160



<https://www.facebook.com/jicadpub1and2>



<https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>

